



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, 37.6 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх заалт, “Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн дүрэм”-ийн 4.4 дэх заалт, Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам, Монгол Улсын их сургуулийн дүрмийн 5.2.3.4, 5.3.8.3 дахь заалт, Монгол Улсын их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.4 дэх заалт, Монгол Улсын их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын их сургуулийн Эндаументын сангийн журам”-ыг хавсралт ёсоор баталж, 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
2. Журмыг Монгол Улсын их сургуулийн эрдмийн хамт олон болон олон нийтэд танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсын их сургуулийн ректор (Б.Очирхуяг)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Х.БАТЖАРГАЛ

1425010017

МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2025 оны ...05... дугаар
сарын ...13... -ний өдрийн 07... дугаар тогтоолын хавсралт



МУИС-ИЙН ЭНДАУМЕНТЫН САНГИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журам нь Монгол Улсын Их Сургууль (цаашид “Сургууль” гэх)-ийг хөгжүүлэх хандив, хөрөнгө оруулалтад суурилсан Эндаументын сан (цаашид “сан” гэх)-г үүсгэн байгуулах, сангийн удирдлага, хөрөнгийг бүрдүүлэх, бүртгэх, хамгаалах, удирдах, сангийн орлогыг зарцуулах, тайлагнах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Сангийн хууль тогтоомж нь Иргэний хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Инновацийн тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам (цаашид “Нийтлэг журам” гэх) болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хэм хэмжээнээс бүрдэнэ.
- 1.3 Сангийн зорилго нь хандивлагчдаас орлого бүрдүүлж түүнийг удирдан өсгөн нэмэгдүүлж сургуулийн хөгжлийг дэмжихэд оршино.
- 1.4 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.4.1 Хандивлагч гэж өөрийн өмчлөлийн эдийн болон эдийн бус хөрөнгө, эсхүл түүний өгөөжийг сайн дурын үндсэн дээр сургуулийн эндаумент санд хариу төлбөргүйгээр шилжүүлэн өгч буй этгээдийг;
 - 1.4.2 Хөрөнгө гэж аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялгийг;
 - 1.4.3 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө гэж үнэ цэний өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат өндөр хөрвөх чадвартай хөрөнгийг;
 - 1.4.4 Эндаументын сан гэж дээд боловсролын сургалтын байгууллагад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ашиг олох зорилгогүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгийг;
 - 1.4.5 Хязгаарлалтгүй эндаумент (Unrestricted Endowment): Хандивыг хүлээн авч буй ашгийн бус байгууллага хөрөнгийг захиран зарцуулах бүрэн эрхтэй байх;

- 1.4.6 Хугацаатай эндаумент (Term Endowment): Тодорхой хугацааны эсхүл тодорхой үйл явдлын дараа үндсэн хөрөнгийг захиран зарцуулах бүрэн эрх хүлээн авагч талд нээгдэх;
- 1.4.7 Хагас эндаумент (Quasi Endowment): Хувь хүн эсхүл байгууллага нь тодорхой зорилго, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор хандивладаг. Үндсэн хөрөнгийг ихэвчлэн хэвээр үлдээдэг ба түүнээс хүртэх хөрөнгө оруулалтын орлогыг хандивлагчийн тодорхойлсны дагуу зарцуулж эсхүл хуваарилах;
- 1.4.8 Хязгаарлалттай эндаументын сан (Restricted Endowment): Үндсэн хөрөнгийг хандивлагчийн санал болгосон хугацаагаар хадгалах ба зөвхөн түүнээс хүртэх орлогыг хандивлагчийн тодорхойлсны дагуу захиран зарцуулах.
- 1.5 Сангийн үйл ажиллагаанд баримтлах зарчим
- 1.5.1 Нээлттэй байх;
 - 1.5.2 Хуульд нийцсэн байх;
 - 1.5.3 Ёс зүйтэй байх;
 - 1.5.4 Талууд ашиг сонирхлын зөрчилгүй байх;
 - 1.5.5 Тооцоо судалгаанд суурилсан байх;
- 1.6 Сангийн үйл ажиллагаанд баримтлах хэм хэмжээ
- 1.6.1 Сангийн үйл ажиллагаа нь хандивлагчид болон хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн байх, сангийн үйл ажиллагааны талаар хөрөнгө оруулагчид үнэн зөв мэдээллийг өгч байх;
 - 1.6.2 Сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр нь эрсдэл багатай, үндэслэл бүхий тооцоо, судалгаанд суурилсан байх;
 - 1.6.3 Хөрөнгө оруулалт хийх хязгаар, хориглох зүйлийг хөрөнгө оруулалтын бодлогод урьдчилан тодорхойлж, түүнийг мөрдөж ажиллах, эрсдэлийн зохистой удирдлага, эрсдэлээс сэргийлэх арга, хэрэгсэлтэй байх;
 - 1.6.4 Эрсдэлийг хэт төвлөрүүлэхгүй байх, хөрвөх чадварын зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;
 - 1.6.5 Сангийн хөрөнгийн удирдлагыг хандивлагчаас тусгаарласан байх, уг санд хандивлагчийн бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг сангийн хөрөнгөөр барагдуулахгүй байх;

ХОЁР. САНГИЙН УДИРДЛАГА

- 2.1 Сангийн эрх барих дээд байгууллага нь сургуулийн Удирдах зөвлөл байна.
- 2.2 Удирдах зөвлөл нь дараах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 2.2.1 Санг үүсгэн байгуулах, татан буулгах;
 - 2.2.2 Сангийн журмыг батлах, журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
 - 2.2.3 Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийг батлах;
 - 2.2.4 Сангийн гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх;
 - 2.2.5 Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад ажиллах нэгжийн зохион байгуулалт, орон тоог тогтоох, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах;

- 2.2.6 Сангийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар гүйцэтгэх захирлын хэм хэмжээг тогтоох;
- 2.2.7 Их хэмжээний хэлцэл хийх эрхийг гүйцэтгэх захиралд олгох;
- 2.2.8 Сангийн хөрөнгийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон орлогыг зарцуулах асуудлаар шийдвэр гаргах;

2.3 Гүйцэтгэх захирал

- 2.3.1 Удирдах зөвлөлийн дарга сангийн гүйцэтгэх захиралтай онцгой нөхцөлт хөдөлмөрийн гэрээ байгуулна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.
- 2.3.2 Гүйцэтгэх захирал нь энэхүү журам болон удирдах зөвлөлийн даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, өмч хөрөнгийг захиран зарцуулах зэргээр сангийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 2.3.3 Гүйцэтгэх захирал нь сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 2.3.4 Гүйцэтгэх захирлын эрх
- 2.3.4.1 Удирдах зөвлөлөөс баталсан хөрөнгө татах, хөрөнгө оруулах стратегийг хэрэгжүүлэх;
- 2.3.4.2 Энэхүү журам болон удирдах зөвлөлийн даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд санг итгэмжлэлгүйгээр төлөөлөх;
- 2.3.4.3 Хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын асуудлаар шийдвэр гаргах;
- 2.3.4.4 Сангийн хөрөнгийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19 дэх хэсэгт заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр гаргах, түүнийг сонгон шалгаруулах;
- 2.3.4.5 Хөрөнгө оруулалтын үр ашгийг тогтмол үнэлэх, нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- 2.3.4.6 Хөрөнгө оруулалтын эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- 2.3.4.7 Сангийн хөрөнгө оруулах хэрэгсэлд байршуулсан хөрөнгийн үр ашгийн талаар санал боловсруулан Удирдах зөвлөлд танилцуулах;
- 2.3.4.8 Жилийн төсвийг Удирдах зөвлөлөөр батлуулж, хэрэгжүүлэх;
- 2.3.4.9 Ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулах;
- 2.3.4.10 Гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд дотоод журам, заавар, аргачлалыг батлах;
- 2.3.5 Гүйцэтгэх захирлын үүрэг
- 2.3.5.1 Гүйцэтгэх захирал нь үйл ажиллагаандаа сургуулийн болон сангийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, холбогдох журмаар хүлээсэн үүргээ үнэнч биелүүлэх;

- 2.3.5.2 Сангийн стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн үр дүнг хариуцах;
- 2.3.5.3 Сангийн хөрөнгө оруулалт татах ажлыг зохион байгуулах;
- 2.3.5.4 Санг төлөөлөн дотоод, гадаадын хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг хангах;
- 2.3.5.5 Удирдах зөвлөлийн хуралдааны үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх;
- 2.3.5.6 Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээг жил бүр Удирдах зөвлөлд тайлагнаж, үнэлэлт, дүгнэлт гаргуулах;
- 2.3.5.7 Сургуулийн болон сангийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх;
- 2.3.5.8 Гүйцэтгэх захирал нь сангийн хөрөнгийг байршуулсан банк, банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны компани зэрэг санхүүгийн байгууллагад дор дурдсан нөхцөл үүссэн тохиолдолд Удирдах зөвлөлд мэдэгдэнэ. Үүнд:
- 2.3.5.8.1. Татан буугдсан, дампуурлын хэрэг үүссэн;
- 2.3.5.8.2. Сангийн нэр хүндэд ноцтой нөлөөлөх нөхцөл бий болсон;
- 2.3.5.8.3. Үйл ажиллагааг эрх бүхий этгээдээс зогсоосон;
- 2.3.5.8.4. Сангийн хөрөнгийн хэмжээ тухайн санхүүгийн жилийн эхний хэмжээнээс 30 болон түүнээс дээш хувиар буурсан;
- 2.3.5.8.5. Гүйцэтгэх захирлын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл.
- 2.3.5.8.6. Удирдах зөвлөл мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор зохих шийдвэр гаргана.
- 2.3.5.9 Гүйцэтгэх захирал хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн нь эрх бүхий этгээд, хөндлөнгийн хяналтын байгууллагаас тогтоогдсон тохиолдолд гэрээнд заасан хариуцлагыг хүлээнэ.

2.4 Хяналтын зөвлөл

- 2.4.1 Удирдах зөвлөлөөс сангийн санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагаанд хяналт тавих Хяналтын зөвлөлийн үүргийг Удирдах зөвлөлийн Санхүү, аудитын төрөлжсөн хороо гүйцэтгэнэ. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа нь бие даасан, хараат бус байна.
- 2.4.2 Хяналтын зөвлөлийн бүрэн эрх
- 2.4.2.1 Сангийн хөрөнгө оруулалтын стратеги, бодлогын баримт бичиг нь сургуулийн алсын хараа, зорилго, зорилтод нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгөх;
- 2.4.2.2 Хөрөнгө оруулалтын стратегийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, дүгнэлт өгөх, шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах;
- 2.4.2.3 Гүйцэтгэх захирлыг дараах тохиолдолд чөлөөлөх саналыг Удирдах зөвлөлд оруулна. Үүнд:
- 2.4.2.3.1 Сангийн холбогдох журмыг ноцтой зөрчсөн нь тогтоогдсон;

- 2.4.2.3.2 Удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээг зөрчсөн, Удирдах зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй;
- 2.4.2.3.3 Сангийн эд хөрөнгийг завшсан, үрэгдүүлсэн, хувьдаа ашигласан;
- 2.4.2.3.4 Ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн, үүсгэх нөхцөл бүрдүүлсэн;
- 2.4.2.3.5 Албан үүрэгтээ хайнга хандаж, сангийн нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн (хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд гэх мэт);
- 2.4.2.4 Сангийн санхүүгийн тайланд аудит хийсэн байгууллагын аудитортой харилцах, санал солилцох;
- 2.4.2.5 Шаардлагатай тохиолдолд сангийн үйл ажиллагаанд аудит хийлгэх саналыг Удирдах зөвлөлийн даргад гаргах;
- 2.4.2.6 Шаардлагатай тохиолдолд Удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах саналыг Удирдах зөвлөлийн даргад гаргах;
- 2.5 МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн эндаументын асуудал хариуцсан төрөлжсөн хороо
- 2.6 МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн эндаументын асуудал хариуцсан төрөлжсөн хороо нь дараах эрхийг хэрэгжүүлнэ.
- 2.6.1 Эндаументын сантай холбоотой журмыг хэлэлцэх, санал өгөх;
- 2.6.2 Эндаументын сангийн бодлогыг боловсруулах, хэрэгжилтийг үнэлж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргах;

ГУРАВ. САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ

- 3.1 Сангийн хөрөнгө оруулалт нь дараах хэлбэртэй байна.
- 3.1.1 Хязгаарлалтгүй эндаумент
- 3.1.2 Хугацаатай эндаумент
- 3.1.3 Хагас эндаумент
- 3.1.4 Хязгаарлалттай эндаумент
- 3.2 Сангийн хөрөнгө нь дараах хэлбэрийн хандив, тусламж, тэтгэлэг, сургуулийн эрдэм шинжилгээ, инновацын ажлын санхүүжилтийн шимтгэл, сангийн өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
- 3.2.1. хандивлагчаас бэлэглэсэн, шилжүүлсэн, гэрээсэлсэн мөнгөн хөрөнгө, үнэт цаас түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл;
- 3.2.2. хандивлагчаас шилжүүлсэн барилга байгууламж болон түүнтэй адилтгах үл хөдлөх хөрөнгө;
- 3.2.3. хандивлагчаас өгсөн лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж бодис;
- 3.2.4. сургуулийн сургалт, судалгааны нэгж (бүрэлдэхүүн, салбар, ахисан түвшний сургууль, тэнхим, хүрээлэн, төв, лаборатори, номын сан, шинжлэх ухааны парк, ахлах сургууль)-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тусгай зориулалтын дагуу олгосон хандив, тусламж;

3.2.5. үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө;

3.2.6. эрдэм шинжилгээ, инновацын төсөлт ажил, лицензийн гэрээний санхүүжилтийн шимтгэл;

3.2.7. аж ахуйн нэгжийн албан татварын хөнгөлөлт;

3.2.8. сангийн үйл ажиллагааны орлого;

3.2.9. бусад хандив



ДӨРӨВ. САНГИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

- 4.1 Сангийн үйл ажиллагааг хариуцах нэгж нь МУИС-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан нэгж байна.
- 4.2 Сангийн нягтлан бодох бүртгэлийг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-д нийцүүлэн Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, МУИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.
- 4.3 Санд эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх
 - 4.3.1 Хязгаарлалтгүй эндаументын хэлбэрээр санд эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэхэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг мөрдөнө.
 - 4.3.2 Хязгаарлалтгүй эндаументын хэлбэрээс бусад хэлбэрээр санд эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэхэд Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу сангийн дансанд эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх бүртгэл хийнэ.
- 4.4 Сангийн хандив, хөрөнгийг хүлээн авах, бүртгэх ажлыг сургуулийн хөрөнгө оруулалт хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.
- 4.5 Энэхүү журмын 3.2 дахь хэсэгт заасан хандив, хөрөнгийг сургуулийн эндаумент сангийн дансанд байршуулан бүртгэж, сургуулийн санхүүгийн тайланд тусгана.
- 4.6 Хөрөнгө оруулалт хариуцсан нэгж нь хандив, хөрөнгийг хүлээн авсан тухай баримтыг 2 хувь үйлдэж, хандивлагчид 1 хувийг албан ёсоор хүлээлгэж өгнө.
- 4.7 Хандиваар хүлээн авсан хөрөнгийн талаарх мэдээллийг хөрөнгө оруулалт хариуцсан нэгжийн тэмдэг, гарын үсгээр баталгаажуулан сургуулийн Удирдах зөвлөлд танилцуулна.
- 4.8 Санд хөрөнгийг хүлээн авах, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхэд тухай бүрд тухайн хөрөнгийн үнэлгээг хийлгэнэ.
- 4.9 Сангийн хөрөнгийн бүтцэд байгаа үл хөдлөх хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгө, эрхийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хөндлөнгийн үнэлгээчин гүйцэтгэнэ.
- 4.10 Үнэлгээчин, эсхүл үнэлгээ хийх эрх бүхий хуулийн этгээд нь хөрөнгө оруулалтын нэгж болон аудитын компани, түүний ажилтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд байхыг хориглоно.

ТАВ. ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

- 5.1 Хугацаатай эндаумент, хагас эндаумент болон хязгаарлалттай эндаумент хэлбэрийн хөрөнгө оруулалтын хөрөнгийг хандивлагчийн санал болгосон зориулалтын дагуу зарцуулах буюу хадгална. Хязгаарлалтгүй эндаумент хэлбэрийн хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгө оруулалтыг ашиг олох зориулалтгүйгээр захиран зарцуулахыг хориглоно. Сангийн нийт хөрөнгийг жилээс жилд өсгөх бодлого баримтална.
- 5.2 Удирдах зөвлөлөөс сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийг баталж хэрэгжүүлнэ. Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт дараах зүйлийг заавал тусгасан байна. Үүнд:
- 5.2.1 хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл, сангийн хөрөнгийг үр ашигтай өсгөн нэмэгдүүлэх үндэслэл, тооцоо;
 - 5.2.2 сангийн активын бүтцэд тавигдах шаардлага;
 - 5.2.3 хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулалтын хэрэгслийн жагсаалт, хязгаарлалт;
 - 5.2.4 энэ журмын 5.3.1 дэх хэсэгт заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрд хөрөнгө оруулсантай холбогдон үүсэж болох эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын арга, хэрэгслийн тухай;
- 5.3 Гүйцэтгэх захирал нь холбогдох журам, гэрээ болон Удирдах зөвлөлөөс баталсан хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт үндэслэн сангийн хөрөнгө оруулалтыг татах болон сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлнэ.
- 5.3.1 Сангийн эргэлтийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэл худалдан авах хэлбэрээр өсгөнө. Сангийн активт дараах хөрөнгө оруулалтын хэрэгсэл байж болно. Үүнд:
- 5.3.1.1 Засгийн газрын гаргасан өрийн хэрэгсэл;
 - 5.3.1.2 аймаг, нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл;
 - 5.3.1.3 Монгол банкны үнэт цаасны арилжаанд оролцох;
 - 5.3.1.4 Банкны тухай хуулийн 3.1.20 дахь хэсэгт заасан арилжааны банканд хадгаламжийн сертификат, хадгаламжийн дансанд байршуулах;
 - 5.3.1.5 гадаад улсын Засгийн газраас гаргасан үнэт цаас;
 - 5.3.1.6 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;
 - 5.3.1.7 Монгол Улсын болон гадаад улсын үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн өрийн хэрэгсэл;
 - 5.3.1.8 үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагддаггүй компанийн өрийн хэрэгсэл;
 - 5.3.1.9 Монгол Улсын болон гадаад улсын нээлттэй хувьцаат компанийн хувьцаа;
 - 5.3.1.10 хаалттай хувьцаат компанийн болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа;
 - 5.3.1.11 хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх;

- 5.3.1.12 үл хөдлөх эд хөрөнгө болон үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших эрх;
- 5.3.1.13 хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан бусад санхүүгийн хэрэгсэл.
- 5.3.2 Сангийн эргэлтийн бус хөрөнгийг түрээслүүлэх, ашиглуулах хэлбэрээр өсгөнө.
- 5.4 Их хэмжээний хэлцэл
- 5.4.1 Сан дээр бүртгэлтэй байгаа нийт хөрөнгийн 10 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг удирдахтай холбогдсон хэлцлийг их хэмжээний хэлцэлд тооцно.
- 5.4.2 Удирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх эрхийг гүйцэтгэх захиралд олгох эсэхийг шийдвэрлэнэ.
- 5.5 Сангийн хуримтлалыг өсгөн нэмэгдүүлэх зорилгоор сан үүсгэн байгуулагдсан эхний 3 жилд сангийн үйл ажиллагааны ашгийн 50-аас доошгүй хувиар санд хөрөнгө оруулалт хийнэ.

ЗУРГАА. САНГИЙН ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ

- 6.1 Удирдах зөвлөл нь сангийн хөрөнгийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон орлого, ашгийг зарцуулах асуудлаар жилд нэгээс доошгүй удаа хуралдаж, шийдвэр гаргана.
- 6.2 Сангийн хандив, орлого, ашгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:
- 6.2.1 сургуулийн урт хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;
- 6.2.2 нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;
- 6.2.3 судалгаа, эрдэм шинжилгээ, инновацын төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;
- 6.2.4 оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор сургуулийн үндсэн бүтцэд эрдэм шинжилгээний хүрээлэн, сургалт, судалгааны, бизнес инкубатор, технологи дамжуулах төв, гарааны компани, шинжлэх ухааны парк, технологи, инновацын кластер, туршилт үйлдвэрлэлийн болон эдгээртэй адилтгах нэгжийг бие даан эсхүл хамтран байгуулж, үйл ажиллагааг санхүүжүүлэх;
- 6.2.5 сургуулийн сургалтын орчин, оюутны дотуур байрны нөхцөлийг сайжруулах;
- 6.2.6 лабораторийн болон сургалтын тоног төхөөрөмж худалдан авах;
- 6.2.7 залуу багш нарыг гадаадын их, дээд сургуулийн чадавхжуулах сургалтад хамрагдах, магистрант, докторант нарыг судалгааны туслахаар ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;
- 6.2.8 сургуулийн нэрэмжит сургалтын тэтгэлгийг өөрийн сургуулийн суралцагчдад олгох;

6.2.9 санд хөрөнгө оруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сургалт явуулах, судалгаа шинжилгээ хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг дэмжлэг үзүүлэх

6.2.10 Хагас эндаумент буюу 1.4.5 дахь хэсэгт заасан тодорхойлолтын дагуу хөрөнгө оруулагчаас санал болгосон зориулалтын дагуу зарцуулах;

6.3 Сангийн хөрөнгө, орлогыг журмын 6.2 дахь хэсэгт зааснаас бусад зориулалтаар зарцуулах, ашиглах, худалдан борлуулах, бусад шилжүүлэхийг хориглоно.

ДОЛОО. САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХ

- 7.1 Сангийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл нээлттэй, ил тод байна.
- 7.2 Сан нь сургуулийн Удирдах зөвлөл, ректор, хандивлагчдад хагас жил тутам тогтмол тайлан гаргаж байх үүрэгтэй. Тайланд хөрөнгө оруулалтын стратеги, сангийн үйл ажиллагаа, хөрөнгийг хэрхэн хуваарилж зарцуулсан зэргийг нарийвчлан тусгана.
- 7.3 Сангийн орлого, зарлагын шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу сургуулийн цахим хуудсанд байршуулна.
- 7.4 Сангийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг Шилэн дансны тухай хуулиар зохицуулна. Шаардлагатай тохиолдолд гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг хөлслөн ажиллуулж болно.
- 7.5 Сангийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын байгууллагын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна. Жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд хийсэн аудитын байгууллагын шалгалт нь ээлжит байна.
- 7.6 Сангийн орлогыг энэхүү журмын 6.2 дахь хэсэгт заасны дагуу зарцуулсан эсэхэд хандивлагч, суралцагч, багш, ажилтан хяналт тавьж, саналаа сургуулийн Удирдах зөвлөлд гаргаж болно.
- 7.7 Сангийн баримт бичгийг сургуулийн баримт хадгалах журмын дагуу хадгалах ба эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах, хуульд заасан хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

НАЙМ. САНГИЙН ГИШҮҮНЧЛЭЛ, ХАНДИВЛАГЧДЫГ АЛДАРШУУЛАХ

- 8.1 Сан нь хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгийн хэлбэр, хэмжээнээс хамааруулан хандивлагч тал татгалзаагүй бол хандивлагчдад дараах алдрыг хүртээж, өргөмжлөл гардуулна. Хандивлагч хэдэн ч удаа хандивлаж болох бөгөөд нийт хандивыг нийлбэр дүнгээр тооцно.
 - 8.1.1 Таван тэрбумаас дээш төгрөг, түүнтэй дүйцэхүйц хэмжээний хөрөнгө хандивлагчийг “Таван од” зэрэглэлийн хандивлагч гэж цоллон, “Таван од зэрэглэлийн хандивлагч 01-999” дугаар бүхий өргөмжлөл гардуулна.
 - 8.1.2 Нэг тэрбумаас дээш төгрөг, түүнтэй дүйцэхүйц хэмжээний хөрөнгө хандивлагчийг “Дөрвөн од” зэрэглэлийн хандивлагч гэж цоллон, “Дөрвөн од зэрэглэлийн хандивлагч 1001-9999” дугаар бүхий өргөмжлөл гардуулна.

- 8.1.3 Нэг зуун саяас дээш төгрөг, түүнтэй дүйцэхүйц хэмжээний хөрөнгө хандивлагчийг “Гурван од” зэрэглэлийн хандивлагч гэж цоллон, “Гурван од зэрэглэлийн хандивлагч 10,001-99,999” дугаар бүхий өргөмжлөл гардуулна.
- 8.1.4 Арван саяас дээш төгрөг, түүнтэй дүйцэхүйц хэмжээний хөрөнгө хандивлагчийг “Хоёр од” зэрэглэлийн хандивлагч гэж цоллон, “Хоёр од зэрэглэлийн хандивлагч 100,001-999,999” дугаар бүхий өргөмжлөл гардуулна.
- 8.1.5 Нэг саяас дээш төгрөг, түүнтэй дүйцэхүйц хэмжээний хөрөнгө хандивлагчид “Нэг од” зэрэглэлийн хандивлагч гэж цоллон, “Нэг од зэрэглэлийн хандивлагч 1,000,001-9,999,999” дугаар бүхий өргөмжлөл гардуулна.
- 8.2 Сан нь хандивлагчдын сургуулийн хөгжилд оруулсан хувь нэмрийг алдаршуулах, олон нийтэд сурталчлах зорилго бүхий “Алдрын самбар” бий болгож, сургуулийн хананд байршуулж, сургуулийн цахим хуудасны тусгай буланд байрлуулна. Хандивлагчийн зөвшөөрлийн дагуу нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.
- 8.3 Хандивлагчийн хандивын хэлбэр, хэмжээнээс хамааруулан бүрэлдэхүүн, салбар, ахисан түвшний сургууль, тэнхим, хүрээлэн, төв, лаборатори, номын сан, шинжлэх ухааны парк, ахлах сургуулийг Хандивлагчийн нэрэмжит болгож болно.
- 8.4 Хандивлагч нар сангийн гишүүнчлэлээр элсэж, сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно. Хандивлагчийн хөрөнгө оруулсан хандивын зорилгоос шалтгаалан төрөл бүрийн гишүүнчлэлийн статустай байна.
- 8.5 Гүйцэтгэх захирал мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө оруулсан хандивлагч талын зөвшөөрлөөр хүчин чармайлт гарган ажилласан дундын зуучлагчид дараах байдлаар нэг удаагийн урамшуулал олгож болно. Үүнд:
- 8.5.1 Хязгаарлалтгүй эндаументын мөнгөн дүнгийн 10 хувь хүртэл;
- 8.5.2 Хугацаатай эндаументын бүрэн эрх хүлээн авсны дараа мөнгөн дүнгийн 10 хувь хүртэл;
- 8.5.3 Хагас эндаументын эхний жилийн орлогын 20 хувь хүртэл;
- 8.5.4 Хязгаарлалттай эндаументын эхний жилийн орлогын 20 хувь хүртэл;

ЕС. БУСАД

- 9.1 Хандивлагчдын эрх, үүргийг тусгай гэрээгээр зохицуулна.
- 9.2 Сангийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно. Үүнд:
- 9.2.1 Сан нь журмын зорилгод нийцэхгүй үйл ажиллагаа явуулах;
- 9.2.2 Сангийн хөрөнгө, орлогыг сургуулийн Удирдах зөвлөлийн дарга, гишүүд, ректор, удирдах албан тушаалтнуудыг урамшуулах;
- 9.2.3 Сангийн орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж бусад байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх, тэдгээрийн өмнөөс тайлбар хийх;
- 9.2.4 Сан нь ямар нэгэн сонгууль, улс төрийн сурталчилгаанд оролцох, хандив өгөх;

- 9.2.5 Хуулиар хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ хууль бусаар эрхэлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс хандив, тусламж авах;
- 9.2.6 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбогдол бүхий этгээдээс хандив, тусламж авах;
- 9.3 Сангийн хөрөнгийн орлогыг зориулалтын бусаар зарцуулах шийдвэр гаргасан, зарцуулсан албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 9.4 Санг хууль, журамд заасан үндэслэлийн дагуу Удирдах зөвлөлийн шийдвэрээр татан буулгаж болно.
- 9.5 Сан татан буугдахад зохих төлбөрийг хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг сургуульд шилжүүлж, зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.



xxx